

СУРГАЛТЫН ЗАРИМ ИДЭВХТЭЙ АРГУУДЫГ ХЭРЭГЛЭЖ ХЯТАД ХЭЛЭЭР УНШИХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Т.Энэбиш¹

¹Ховд Их Сургууль

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Л.Нарантуяа

Үндэслэл

Дэлхий нийтээр даяарчлалын тухай ярьж буй энэ эрин зуунд, нийгэм, шинжлэх ухаан, аливаа дэвшилтэт хөгжилтэй хөл нийлүүлэн алхахад хятад хэл эзэмших зайлшгүй шаардлага урган гарч байна. Хятад хэлийг сайн сурахад тухайн суралцагчийн өөрийн идэвх сонирхол, хичээл зүтгэл аливааг бие даан суралцах чадвар хамгийн чухал бөгөөд үүн дээр тухайн хэлийг зааж буй багшийн арга зүй, ур чадвар, оюутнуудыг удирдаж хэрхэн сурах эрмэлзлэлийг нь бадраах нь нэн чухал ач холбогдолтой. R.Harris “Уншина гэдэг харилцааны тодорхой нөхцөлд зохиогч, уншигч хоёрын хооронд явагдаж буй харилцааны идэвхтэй үйл юм” гэсэн бол, хэл шинжээч эрдэмтэн Goodman “Унших үйл гэж сэтгэхүй буюу хэлэхүй гэсэн хоёр үйлдлээр гүйцэтгэх сэтгэл судлал буюу хэл шинжлэлийн тааварт тоглоом” гэж тус тус тодорхойлсон байна.

Уншлага гэдэг нь бичгийн текстэнд агуулагдсан мэдээллийг авахад чиглэгдсэн хэл ярианы үйл ажиллагааны нэг төрөл бөгөөд уншлагын зорилго нь тухайн текстэнд буй утгын холбоо, мэдээллийг хараагаар мэдрэн хүлээн авч сэтгэхэд оршдог. Хятад хэлийг сурахад уншлага нь маш олон төрлийн ач хойдбогдолтой зөвхөн тухайн хэлийг эзэмшээд зогсохгүй тухайн улсын түүх, соёлтой танилцуулж, мэдлэгийн хүрээг тэлж байдаг. Уншлагын төрлүүдийг хэл шинжээчид 3-4 төрөлд ангилж авч үздэг. Үүнд: Гүйлгэж унших, танилцах уншлага, судлах уншлага, эрэл хайгуул хийж унших гэж ангилна.

Хятад хэл дээр унших чадвар нь хятад хэл суралцагчдын сургалтын үндсэн хэсэг мөн. Унших нь ярих, сонсох, бичихийн адилаар хэлэхүйн үйл ажиллагааны бие даасан төрөл ба өөрийн онцлог шинжтэй байдаг. Хятад хэл суралцагчдын унших чадварыг хөгжүүлэхийн тулд сургалтын идэвхтэй аргуудыг ашиглах нь үр дүнд богино хугацаанд хүрч болох, бүтээлч үйл ажиллагаа учир эдгээр аргуудын талаар уг өгүүлэлд хөндөн тавьж байна. Дараах сургалтын идэвхтэй аргуудыг унших хичээлд хэрэглэх нь зүйтэй байгаа юм. Үүнд:

Чангаар унших-Хятад хэлийг эхлэн суралцагчид чангаар унших нь уншиж сурах анхан шатны үйл ажиллагаа болдог. Чангаар унших явцад суралцагч хятад хэлний авианы дуудлага, ханзны

зурлага, хөг, утга, бичих дараалал, үгс хоорондын таслал, зогсолт зэргийг мэдэх боломжтой. Энэ арга нь тухайн суралцагчдад унших механизмыг бүрдүүлэх гол арга юм.

Өөртөө унших-Энэ арга нь тухайн суралцагч мэдээллийг өөрөө уншиж, өөрөө утгаа ойлгох арга юм. Хятад хэл анхлан суралцагчдад энэ аргыг аль болох бага хэрэглэх хэрэгтэй. Учир нь өөрөө унших явцад хөндлөнгийн хараа хяналтгүй байдаг учраас авиа, дуудлага, хөгийн алдаа гаргах магадлалтай ба цаашид энэ алдаагаа засаж чадалгүй алдаатай хэвээр үлдэх эрсдэлтэй байдаг. Орчуулгатай болон орчуулгагүй унших нь хятад хэл суралцагчдын аль ч түвшинд хэрэглэх боломжтой арга юм. Бэлтгэлтэй уншлага гэдэг нь хэлний дуудлагын бэрхшээлийг үгүй болгох зорилгоор сэдвийг уншихаас өмнө сэдэвт өгөгдсөн хүнд үг, хэллэгийг адил төстэй лексикээр орлуулан тайлбарлах, үг зүй болон өгүүлбэр зүйн бэрхшээлд тодорхой тайлбар өгч дүн шинжилгээ хийсний дараа явуулдаг унших арга юм.

Бэлтгэлгүй унших арга нь тухайн сэдвийг харьцангуй хөнгөвчилсөн аргаар унших ба тухайн сэдэвт буй шинэ үг хэллэгийг суралцагсад заавал толь бичгээс харах буюу багшийн дэмжлэггүйгээр өөрийн мэдрэмжинд тулгуурлан ойлгох уншилт юм.

Ангид унших, гэрт унших нь уншиж байгаа байрлал нь ялгаатай. Суралцагсaдын унших дадлага туршлагаас хамаарч хаана унших нь өөрт нь илүү өгөөжтэй болохыг тодорхойлдог. Тухайн сэдвийг суралцагсад гэртээ уншиж бэлтгэснээр хичээл дээр цаг хэмнэх сайн талтай.

Хамтын уншлага нь хичээлийн өгөгдсөн сэдвийг хоёр суралцагч өгүүлбэр өгүүлбэрээр нь ээлжлэн уншиж бие биедээ ойлгосноо ярьж өгөх арга юм. Энэ нь багаар ажиллах аргын нэг хэлбэр бөгөөд багш суралцагчдын унших чадварыг харгалзан багийг бүрдүүлнэ. Хамтын уншлагыг явуулахад текстийг ганцаарчлан уншихаас 2-3 дахин илүү цаг зарцуулдаг боловч үр дүн нь өндөр.

Чиглүүлэгчтэй уншлагын арга нь өгөгдсөн сэдвийг өөрсдөө унших ба тодорхой хугацааны дараа багш асуулт асууж ярилцлага өрнүүлнэ. Энэ нь гол санааг ойлгох, утгыг харилцан ярилцах, бие биедээ асуулт тавьж сургах ач холбогдолтой. Уг аргыг уран зохиол ба мэдээлэл бүхий сонин

сэтгүүлийн хайчилбарыг ашиглан явуулбал илүү үр дүнтэй ба уншиж буй сэдэв нь суралцагсадын сонирхолыг татсан байх нь чухал.

Сэтгэн бодохуйн дасгалтай унших арга нь сэдвийг бүрэн ойлгохыг шаарддаггүй ба зохиолын төгсгөл хэсгийг үлдээж бие даан таамаглал дэвшүүлэх боломж олгодог. Энэ арга нь үг зүйн баялаг сан шаарддаг тул ахисан түвшиний суралцагчдад хэрэглэх нь тохиромжтой.

Хамтран унших ба бусдын алдаанаас суралцах арга нь багш урьдчилан бэлдсэн текстийг анги дунд нь өгч суралцагч нэг бүрээр уншуулах ба унших явцад гарсан авиа зүйн алдааг нэг өгүүлбэр уншиж дууссаны дараа суралцагсадаар өөрсдөөр нь алдааг нь олуулан засуулахад чиглэгдэнэ. Энэ арга нь хүн бүрийг хичээлд хамруулах, асуудал шийдвэрлэх, өөрийн байр суурийг илэрхийлэх зэрэг дадлыг суралцагчдад олгох давуу талтай.

Багцлан уншуулж сургах арга энэ нь хурдан уншихад шаардлагатай байдаг ба үгчилж биш утгачилж уншиж ойлгоход сургах явдал юм.

Дээрх аргуудаар ХИС-ийн ГХСС-ийн Соёл судлалын тэнхимийн хятад хэлний орчуулагчийн ангийн 2, 3 ангид туршилтын хичээлийг 2018-2019 оны хичээлийн жилийн 1-2 улиралд явуулсан болно. Хичээл зааж дууссаны дараагаар нийт суралцагчдаас судалгаа авч хичээлийн үр дүнг тодорхойлсон болно. Сургалтанд хэрэглэсэн аргуудаас хамгийн тохиромжтой 4 аргыг нэрлэнэ үү гэхэд хамтран унших арга-56%, чиглүүлэгчтэй уншлагын арга-28%, сэтгэн бодохуйн дасгалтай унших арга-12%, өөртөө унших арга гэж 4% нь хариулсан байна. Үүнийг графикаар харуулбал:

Мөн суралцагчдын унших чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн дасгал, даалгавар одоогийн байдлаар ашиглаж байгаа хятад хэлний сурах бичиг, гарын авлага, дасгалын нийт 50 номноос түүвэрлэж анализ хийлээ. Үүнд: Уншаад тест бөглөх, асуултанд хариулах-15.6%, уншаад орхигдсон үгийг нөхөх-9.8%, уншаад текстийн асуултанд зөв, буруу хариулт өгөх-14.1%, бичвэрийг уншаад орхигдсон үгийг бөглөх-11%, текст эвлүүлэх-13.6%, уншаад зөв дараалалд оруулах-7.2%, уншаад өгөгдсөн зурган дээр ажиллах-6%, уншаад алдааг засах-5.7%, уншаад асуулт зохиох-4.8%, цэг тэмдэгийг текстэнд тавих-8.9%, чангаар унших-3.7%, уншаад өгүүлбэр зохиох-4.4% байна. Судалгаанаас харахад сургалтын аль ч шатанд уншаад орчуулан ойлгох нь зонхилж байна.

Дүгнэлт

Аливаа хэлийг ямар хэмжээнд эзэмшсэнийг дүгнэх шалгуур нь унших чадвар байдаг. Иймээс хятад хэл суралцагчдын унших чадварыг хөгжүүлэх нь багш нарын хувьд маш чухлаар тавигдах асуудал юм. Хятад хэлээр унших чадварыг улам хөгжүүлэхийн тулд бие даан унших даалгавар өгөх хэрэгтэй ба энэ нь хятад хэл сайн сурах хөшүүрэг болно. Сургалтын материалаг баазыг дээшлүүлэх, сургалтыг илүү үр дүнтэй болгох, сургалтанд орчин үеийн аргыг туршин хэрэглэх, дадал болгох зэрэг санал дэвшүүлж байна.

Хятад хэлээр уншиж ойлгох нарийн төвөгтэй бөгөөд суралцагчдын идэвхи чармайлт, мэдлэгийн хуримтлал, тухайн хэлийг сурсан түвшинээс шалтгаалах тул багшийн удирдан чиглүүлэх авьяас, мэргэжлийн ур чадвар, суралцагч нэг бүрийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан үзэх зэрэгтэй салшгүй нягт уялдаа холбоотой.

IMPROVING CHINESE READINGS USING SOME ACTIVE TEACHING METHODS

Rezume: Reading skills in Chinese are an integral part of Chinese language training. Reading, like speaking, listening, and writing, is an independent type of speech activity and has its own characteristics. The use of active learning methods to develop Chinese learners' reading skills is a creative activity that can be achieved in a short period of time. The following active learning methods should be used in reading lessons.

Ном зүй

1. Клычникова.З.И (1973). Психологические особенности обучения чтению на иностранном языке.
2. Митрофановна.О.Д (1981). Структура научного текста и обучения монологической речи.
3. Лхамаа Б. (2013). Унших чадварыг хөгжүүлэхэд орчин үеийн сургалтын шинэлэг аргуудыг ашиглах нь. Гадаад хэл заах арга зүйн асуудал сэтгүүл.
4. Мягмардарь. Х (2012). Англи хэлээр унших чадвар хөгжүүлэх арга зүйн асуудалд. Гадаад хэл заах арга зүйн асуудал сэтгүүл.
5. Нарантуяа. С (2013). Оюутан суралцагчдын унших чадварыг гадаад хэл дээр хөгжүүлэх арга зүйн асуудалд. Гадаад хэл заах арга зүйн асуудал сэтгүүл.
6. Наранцэцэг Б. (2004). Сургалтын шинэ аргууд тэдгээрийг хэрэглэх боломж. УБ.